

Байгаль эхээ хүндэлж, ирээдүйгээ хамгаална

Булнайн нуруунд ойжуулалт хийснээр 4 метрээс дээш өндөртэй 10 мянга орчим модоор шинэсэн ой тэлжээ.

► 5

2024 оны онцлох 15 ажил

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт, байгаль хамгаалал зэрэг олон чиглэлд хүрч ажилласнаас дараах 15 ажлыг онцлон нэрлэж байна.

► 6-7

Австралийн туршлагаас

Австрали даяар алдартай Хантерийн хөндий нь хөдөө аж ахуй, аялал жуулчлал, уул уурхай зэрэгцэн хөгжсөн газар юм.

► 8

Редакцийн зурвас

“Овоот” коксжих нүүрсний цогц төсөл эрчимжинэ

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт хэрэгжих “Овоот” коксжих нүүрсний цогц төсөл нь бүтээн байгуулалтаар эхлэн эрчимжиж байна. “Хургатай Хайрхан” ХХК нь Монгол Улсад орон нутгийн хөгжлийг дэмжсэн хариуцлагатай уул уурхайн шинэ жишиг тогтоох зорилготой. “Овоот” коксжих нүүрсний цогц төсөл нь орон нутгийн хөгжил, дэд бүтцийн шинэчлэл, ажлын байр, эдийн засгийн олон талын боломжуудыг хослуулсан цогц бүтээн байгуулалт юм.

Уг төслийн хамгийн чухал дэд бүтэц болох Улиастай-Мөрөн чиглэлийн нийтийн эзэмшлийн хатуу хучилттай авто замын барилгын ажил удахгүй эхлэх төлөвтэй. Энэхүү замыг барих Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлэлцээр үргэлжилж байна. Барилгын ажлыг “Хургатай Хайрхан” ХХК өөрөө хийхгүй ба зохих зөвшөөрөлтэй, туршлагатай зам барилгын гүйцэтгэгчийг татан оролцуулна. Тендер шалгаруулалт нь орон нутгийн ажлын байр, худалдан авах боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. “Хургатай Хайрхан” ХХК нь нүүрс тээвэрлэлт, борлуулалт эхлэхээс өмнө энэхүү хатуу хучилттай замыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулахыг эрхэм үүрэг болгон ажиллаж байна.

2025 оны гуравдугаар улиралд эхлүүлэхээр төлөвлөж буй бусад бүтээн байгуулалтад богино хугацааны сургалтын бааз, ажилтны байнга байрлах кемп байгуулах, шаваас зайлуулах, нүүрс боловсруулах үйлдвэр барих зэрэг уурхайн дэд бүтэц багтаж буй. Энэхүү ажил эхэлснээр орон нутагт олон ажлын байр бий болж, худалдан авах боломж бүрдэх бөгөөд тус компани дотоодын түншүүдтэй хамтран ажиллахад таатай байна.

Одоогоор “Хургатай Хайрхан” ХХК байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, газар ашиглах зөвшөөрөл, холбогдох бичиг баримтыг хууль, журмын дагуу боловсруулж байна. “Овоот” коксжих нүүрсний цогц төсөл нь Хөвсгөл нутаг төдийгүй хойд бүсийг хамарсан боломж, хөгжлийг өдөөж, урт хугацааны тогтвортой хөгжлийн эхлэл болно. Бүтээн байгуулалт эрчимжихийн хэрээр ирээдүйн боломжууд ойртож байна.

Шинэ боломж

Мөрөн-Улиастайн хурдны зам ашиглалтад орсноор орон нутгийн хөгжилд ямар ашиг тустай вэ?



Авто замын дагуух амрах цэг.

Мөрөн-Улиастай чиглэлийн авто замын бүтээн байгуулалт нь Монгол Улсын баруун, хойд, төвийн бүсийн нийтийн

тээврийн дэд бүтцийн томоохон өөрчлөлт юм.

Орон нутгийн хөгжилд төдийгүй бүс

нутгийн хөгжлийн тэнцвэртэй өсөлтөд хүчтэй нөлөө үзүүлэх стратегийн ач холбогдолтой бүтээн байгуулалт юм.

► 4

“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн 2025 оны III улирлын төлөвлөгөө:

Бүтээн байгуулалт эхэлж, орон нутгаас ажиллах хүчийг бүрдүүлнэ

“Хургатай Хайрхан” ХХК 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө орон нутагт танилцуулж байна. “Овоот” коксжих нүүрсний цогц төслийг энэ онд эхлүүлснээр орон нутагт ажлын байр, орон нутгийн бизнес эрхлэх боломж эрс нэмэгдэнэ. Удахгүй зам барилгын ажил эхэлж, “Ногоон тэжээл” хөтөлбөр дахин хэрэгжиж, “Овоот” коксжих нүүрсний цогц төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, хэт ачааллыг арилгах ажлыг газар дээр нь эхлүүлэхээр төлөвлөж байна. Орон нутагтай хийх уулзалт, хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.

АВТО ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ЭХЭЛНЭ

“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн хамгийн чухал дэд бүтэц болох хатуу хучилттай авто замын ажлыг энэ онд эхлүүлэхээр төлөвлөжээ. Энэ замыг барих Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлэлцээрийг хэлэлцэж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээг байгуулсны дараа зам барилгын ажлын тендерийг олон нийтэд зарлана. Зам барилгын гүйцэтгэгчийг сонгохдоо орон нутгийн иргэдийг ажилд авах, орон

нутгаас бараа, үйлчилгээ худалдан авах зэрэг шалгуурыг онцгой анхаарч үзнэ. Энэ нь орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн эргэлтийг дэмжих бодит алхам болно гэж тус компани үзэж байна.

АЖЛЫН БАЙР, ХАМТЫН АЖИЛЛАГАА НЭМЭГДЭНЭ

“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт зам барилгын ажилтай зэрэгцэн урагшилна. Талбайн дэд бүтцэд барилга угсралт, ашиглалтын явцад ажилчдыг байрлуулах байнгын лагерь, оффис, цех, агуулахын барилга байгууламж, нүүрс олборлолтод бэлтгэх даацын олборлолт зэрэг багтана. Нүүрс боловсруулах үйлдвэрийн барилгын ажлыг 2025 оныг дуустал газар дээр нь эхлүүлэхээр төлөвлөж байна. Тус компани энэхүү ажлыг дэмжихэд нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулахаар идэвхтэй ажиллаж байгаа бөгөөд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан ашиг сонирхлын илэрхийллийг сурталчлах болно.

“НОГООН ТЭЖЭЭЛ” ХӨТӨЛБӨР ҮРГЭЛЖИЛНЭ

2020 оноос хэрэгжиж буй “Ногоон

тэжээл” хөтөлбөрийг 2025 онд тав дахь жилдээ хэрэгжүүлэх гэж байгаа бөгөөд зургаадугаар сараас тэжээл тариалах ажил эхлэн баруун, хойд бүс нутагт мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхээр төлөвлөжээ. Энэ нь орон нутгийн бизнесийг дэмжих, тухайн бүс нутагт эдийн засгийн олон талт байдлыг бий болгоход чиглэсэн алхам юм. Түүнчлэн зуд, турханыг даван туулахад бодитой хувь нэмэр оруулж байсан шигээ нутгийн малчдадаа хөнгөвчилсөн үнээр үргэлжлүүлэн нийлүүлэх зорилгоо хэвээр хэрэгжүүлэх санааг илтгэж байгаа юм.

ИРГЭДТЭЙ ТОГТМОЛ УУЛЗАЛТ ХИЙЖ, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАНА

“Хургатай Хайрхан” ХХК нь төслийн үйл явцын талаар үнэн зөв, бодит мэдээллийг иргэдэд хүргэж байх зорилгоор тогтмол уулзалтууд зохион байгуулж байна. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Их-Уул, Цагаан-Уул, Бүрэнтогтох сумдаас гадна Булган аймгийн Хутаг-Өндөр, Орхон аймгийн Жаргалант сумын иргэдтэй уулзалт хийж, тэдний санал сэтгэгдлийг сонсож, үйл ажиллагаандаа тусган, хамтран ажиллахыг зорьж байна. **ОМ**

Хамтын зорилго-2025

Хамтдаа илүү сайхан ирээдүйн төлөө

“Хургатай Хайрхан” ХХК нь төслөө урагшлуулж буйтай зэрэгцэн нутгийн иргэдтэй хамтран хөгжих, байгаль орчиндоо хүндэтгэлтэй хандах, тогтвортой ажлын байр бий болгох зорилтдоо үнэнч хэвээр байна. 2024 онд компанийн зүгээс хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд нь орон нутгийн иргэдийн амьдралд хүртээмжтэй, урт хугацаанд үр өгөөжөө өгөхүйц байлаа. 2025 онд эдгээр ажлууд улам өргөжин, нутгийн иргэдтэй илүү ойр байж, хамтын хөгжил рүү чиглэхээр байна.



Сургалт, боловсролын тэтгэлэг, ажлын байр нэмэгдүүлэх хөтөлбөрүүд цааш үргэлжилнэ. Ингэснээр залуусыг ажилтай, орлоготой болгож, ур чадварыг нь хөгжүүлэх замаар орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулна.



Байгаль орчны шинэ хяналтын систем хэрэгжүүлнэ. Тухайлбал, агаарын чанарын хяналтын станцууд суурилуулж, газрын доорх усны хэмжилтийг тогтмол гүйцэтгэснээр уурхай, түүний орчны өөрчлөлтийг нийтэд ил тод мэдээлж, орон нутгийн оролцоотой хамтын хяналтыг хэрэгжүүлэх боломжтой болох юм. Мөн төслийн үйл ажиллагааны байгальд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, нөхөн сэргээлтийг үр дүнтэй болгох зорилготой юм.



Иргэдтэй тогтмол харилцах, тэдний санал бодлыг сонсож, шийдвэр гаргах үйл явцад оролцуулах зорилтот ажлыг тогтмолжуулна.



Орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх хөтөлбөрийн нийгэм эдийн засгийн судалгаа хийгдэж байна. Үүний хүрээнд Цэцэрлэг сум болон Хөвсгөл аймаг, цаашлаад хойд, баруун бүсийн хэмжээнд зах зээлийн эрэлт хэрэгцээг судалж, шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг орон нутагт үйлдвэрлэх боломжийг бүрдүүлж, зах зээлтэй холбох ажлуудыг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.

Компанийн мэдээ

2025 ОНЫ

“Хургатай хайрхан” ХХК 2025 он хүртэл “Овоот” төсөлтэй холбоотой хэд хэдэн төслийг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд тэдгээрийн талаарх мэдээллийг тоймлон хүргэж байна.



Геотехникийн судалгаанаас бүтээн байгуулалтад

“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Байнгын хотхон, Нүүрс баяжуулах, бэлтгэх үйлдвэр барихаар төлөвлөж буй газруудад геотехникийн иж бүрэн судалгааг хийсэн.

Эдгээр геотехникийн судалгааг дуусгахын тулд нэгдүгээр сард гүехэн өрөмдлөгийг “Ган хошуу” ХХК хийж, хөрсний дээжийг Улаанбаатар хотын итгэмжлэгдсэн лабораторид шинжлэн, газрын температурыг үе шаттайгаар бүртгэжээ.

Судалгааны үр дүн нь баригдах дэд бүтцийн суурийн зураг төслийг боловсруулахад хувь нэмэр оруулж, ирээдүйн барилга, бүтээн байгуулалтын

найдвартай, тогтвортой төлөвлөлтөд чухал мэдээлэл өгөх болно.

“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг 2025 онд эхлүүлэхээр төлөвлөж байна. Эхний ээлжид барилгын болон ашиглалтын явцад ажилчдыг цэвэр, тохилог орон байраар хангах Байнгын бааз барих нь нэн тэргүүний зорилт юм.

Ажилчдын цэвэрхэн, тохилог байр нь ээлж бүрийн өмнө сайн амрах нөхцөлийг бүрдүүлнэ. Ийн “Хургатай хайрхан” ХХК нь нийт ажилчдынхаа болон тэдний гэр бүлийн сайн сайхны төлөө аюулгүй байдлыг хангаж ажиллах үүрэгтэй билээ.

Тоосгүй тээвэр, байгальд ээлтэй терминал

“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн хүрээнд хэрэгжих дэд бүтцийн томоохон төслүүдийн нэг нь Орхон аймгийн Жаргалант суманд баригдах авто машинаас вагон

руу нүүрс шилжүүлэн ачих төмөр замын терминал юм.

Энэхүү төмөр замын терминал нь нүүрс тээвэрлэх, хадгалах бүх газрыг тоосжилтоос сэргийлж, байгаль орчинд сөрөг нөлөө

Овоотын мэдээ сонин

Сонины зөвлөл:

Д.Ачит-Эрдэнэ
Ц.Батхүү
Т.Маралгоо
Э.Ганхуяг

Дугаар эрхэлсэн:

Н.Ариунтуяа

Сэтгүүлч:

Б.Баянжавзан

Хэвлэлийн дизайнер:

Д.Хулан

Гэрэл зураг:

“Хургатай Хайрхан” ХХК

Хаяг:

Монгол Улс,
Улаанбаатар хот-15170, Чингэлтэй дүүрэг
1-р хороо, Бага тойруу-17, ЖиЖи цамхаг
9 давхар
Утас: +976 7011-6828

Email:

info@khurgataikhairkhan.mn

Website:

www.khurgataikhairkhan.mn

ЭХНИЙ УЛИРАЛД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД



үзүүлэхгүй байх үүднээс материал зөөвөрлөх дэвшилтэт шийдлээр төлөвлөжээ.

Төмөр замын эцсийн буудал ашиглалтад орсноор 100 гаруй ажлын байр бий болж, бүс нутгийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулна гэж тооцоолжээ.

Орхон аймгийн Жаргалант сумын төмөр замын эцсийн зогсоолын геофизик, геотехникийн судалгааг "Black Sand Mineral" ХХК 2025 оны гуравдугаар сард хийсэн.

Урьд нь тухайн газар нутагт байсан цэргийн баазаас газар доорх үлдэгдэл байж болзошгүйг тодорхойлохын тулд геофизикийн судалгаа хийх шаардлагатай байв. Орчин үеийн соронзон орны зураглалын технологийг ашигласан бөгөөд аз болоход анхаарал татахуйц

зүйл олдсонгүй.

Геофизикийн судалгааны ажил дууссаны дараа "Ган хошуу" ХХК геотехникийн судалгааг хийсэн. Үүнд баригдахаар төлөвлөж буй барилгуудын доогуур олон тооны гүехэн нүх өрөмдөж, хөрсний дээж авч Улаанбаатар хотод шинжилгээнд хамруулж, хөрсний хэмжилт, чийгийн хэмжээг бүртгэв.

Эдгээр геофизик, геотехникийн судалгааны зорилго нь төслийн аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангах үүднээс Монгол Улсын Үндэсний стандарт (МНС) болон Барилгын норм дүрмийн (БНБД) шаардлагын дагуу төмөр замын эцсийн буудлын суурь бүтцийн нарийвчилсан суурийн зураг төслийг боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулахад оршиж байв.

Нийгмийн хариуцлага: Түймрийн эсрэг хамтдаа



2025 оны дөрөвдүгээр сарын 13-нд Цэцэрлэг сумын Зуунмод багийн нутаг Дунд Тэрмисийн эх, Барчгарын урд өвөр орчимд гарсан ой хээрийн түймрийг унтраах ажилд "Хургатай Хайрхан" ХХК-ийн таван ажилтан

сайн дураараа оролцжээ. Түймэр унтраах, тархалтыг хязгаарлан цурамд оруулах ажилд компаниа төлөөлөн гар бие оролцсон Б.Дашням, Ө.Одсүрэн, Б.Ганданням, Ч.Амарзаяа, Г.Отгон нартаа талархал илэрхийлье.

Шинэ засмал зам, орчин үеийн тээврийн хэрэгслээр орон нутгийн иргэдэд шинэ боломж олгоно

"Овоот" коксжих нүүрсний цогц төсөл нь Цэцэрлэг сумын нутаг дэвсгэрт олборлолт, боловсруулалтын дэд бүтцийн бүтээн байгуулалт, Улиастай-Мөрөн чиглэлийн нийтийн эзэмшлийн зам талбайн бүтээн байгуулалт, Орхон аймгийн Жаргалант сумын төмөр замын эцсийн буудал барих зэрэг хэд хэдэн томоохон дэд төслөөс бүрдсэн цогц төсөл юм. Нийтийн эзэмшлийн зам талбай, уул уурхай, боловсруулах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг 2025 онд эхлүүлэхээр төлөвлөж байна.

Учир нь "Хургатай Хайрхан" ХХК нүүрс тээвэрлэлтийг зөвхөн авто замаар гүйцэтгэх бөгөөд Евро стандартын, орчин үеийн аюулгүйн тоног төхөөрөмжтэй, утааны ялгаруулалт багатай тээврийн хэрэгсэл ашиглах юм. Мөн



тээврийн маршрутын дагуу хоёр амрах цэг, нэг томоохон тээврийн төв байгуулна. Амрах цэгүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн өрөө, амралтын танхимаас гадна хоол хүнс, худалдаа үйлчилгээний хэсэг байна. Энд нүүрс тээврийн жолооч нар болон тус замаар

зорчин явагч иргэд бууж амрах боломжтойгоороо давуу талтай. Тэгвэл маршрутын дунд хэсэгт байрлах тээврийн төвд тээврийн жолооч нар машин техникийн засвар үйлчилгээнээс эхлээд амрах байр зэрэг бусад шаардлагатай үйлчилгээг авна.



Их-Уул болон Цэцэрлэг сумын иргэдтэй хийсэн уулзалт.

Мэдээллийн ажилтнуудаа чадавхжууллаа

"Хургатай Хайрхан" ХХК-ийн зүгээс Цэцэрлэг сум дахь орон нутгийн болон мэдээллийн ажилтнуудаа чадавхжуулах сургалтыг Улаанбаатар хотноо дөрөвдүгээр сард зохион байгууллаа. Уг хоёр өдрийн сургалтыг "Монголын тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөл"-тэй хамтарч хийсэн бөгөөд иргэний нийгэм болон хэвлэл мэдээллийн байгууллагын сургагч багш нар чиглүүлэн ажилласан юм.

Мэдээллийн ажилтнууд олон нийтийн харилцааны ерөнхий ойлголт, өргөдөл гомдол шийдвэрлэх механизм, уурхайн үйл ажиллагааны үе



шатууд, хэвлэл мэдээллийн үр дүнтэй харилцаа, мэдээллийн дүн шинжилгээ, оновчлол зэрэг

олон талт мэдлэг олгох, чадвар эзэмшүүлэх агуулга бүхий сургалтад хамрагдлаа.

Шинэ боломж

Мөрөн-Улиастайн хурдны зам ашиглалтад орсноор орон нутгийн хөгжилд ямар ашиг тустай вэ?



Овоот төслийн кэмийн зураг төсөл

1

Энэхүү хурдны зам ашиглалтад орсноор тээврийн дэд бүтэц шинэчлэгдэж, орон нутгийн иргэдийн амьжиргаанд эерэг өөрчлөлт авчирч, бизнесийн орчин сайжирч, байгаль орчныг хамгаалахад дэмжлэг үзүүлнэ гэж авто замын ТЭЗҮ-д тусгасан байна. Мөрөн-Улиастай чиглэлийн шинэ зам нь бүс нутгийг холбож, зорчих цаг хугацаа, тээврийн зардлыг бууруулах, орон нутгийн бизнесийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төв болон баруун бүсийг холбосон тогтвортой тээвэр, логистикийн сүлжээ бий болгох ач холбогдолтой. Түүнчлэн энэ авто зам нь зөвхөн нэг төслийн бүтээн байгуулалт биш, харин орон нутгийн эдийн засгийн идэвхжилд чухал нөлөө үзүүлэх зам юм. Орон нутгийн хөгжил, бизнесийн өсөлт, ажил эрхлэлт, аялал жуулчлал гээд олон талын үр өгөөж авчрах, хамтын хөгжилд чиглэсэн стратегийн дэд бүтцийн төслийн жишээ болно хэмээн үзэж байна. Байгальд ээлтэй, эдийн засагт үр өгөөжтэй энэ бүтээн байгуулалт ойрын ирээдүйд Монгол орны баруун бүсийн хөгжилд шинэ хуудас нээх нь дамжиггүй.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ЭЭРЭГ ҮР НӨЛӨӨ
Энэхүү замыг барьж байгуулах явцад 1200-аас доошгүй ажлын байр шинээр бий болно гэж авто замын ТЭЗҮ-д тусгасан. Ингэснээр орон нутгийн иргэдийг орлоготой болгож эдийн засгаа шууд дэмжинэ. Тус компани зам ашиглалтад орсны дараа арчилгаа, хамгаалалтыг хийж, ажлын байрыг хадгалж, тогтвортой орлогын эх үүсвэр болох зорилт тавин ажиллаж байна.

АЮУЛГҮЙ, БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ШИНЭ СТАНДАРТЫН ЗАМ
Тус замыг “CNR 22-004-2016” стандартад нийцсэн 2А

ангиллын хуримтлуулагч зам байдлаар төлөвлөжээ. Төрийн холбогдох байгууллагаас өгсөн техникийн даалгаврын дагуу хурамтлуулагч замд тавигдах шаардлагыг хангасан зураг төслийг боловсруулсан байна. Энэ зам аюулгүй байдал, ашиглалтын чанар, байгаль орчинд учруулах сөрөг нөлөөг багасгах олон давуу талтай. Үүнд дараах төлөвлөлтүүд багтжээ.

Нэмэлт эгнээ: Өгсүүр, үзэгдэх орчин хязгаарлагдмал хэсгүүдэд 3.5 м өргөнтэй, хөндлөн налуу бүхий нэмэлт эгнээ байгуулж, аюулгүй гүйцэх боломж олгохоор хөдөлгөөнийг зохицуулна.

Яаралтай зогсоолууд: Хоёр чиглэлд ойролцоогоор 10-15 км зайтай аваарын зогсоол байгуулна. Эдгээр байршилд замын мөрний өргөнийг 3.0 метр болгон өргөтгөж, зорчих хэсгийн гадна зогсох шаардлагатай тээврийн хэрэгслийг зогсоож, хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангана.


Гүүр: Тэс, Дэлгэр голыг гатлах шинэ гүүрүүд нь үерийн үед ч аюулгүй зорчих боломжийг бүрдүүлэхээр төлөвлөж байна.

Бэлчээрийг хамгаалах: Хатуу хучилттай хурдны замыг

хөгжүүлснээр бэлчээрийн эвдрэлээс урьдчилан сэргийлж, олон тооны шороон зам бүхий эвдэрсэн газруудад бэлчээрийг нөхөн сэргээх боломжтой болно. Хатуу хучилттай замын нөлөөгөөр эвдэрсэн бэлчээрийн 30 орчим хувь нь 3-5 жилийн дотор сэргэдэг гэсэн судалгаа бий.

АМРАХ ЦЭГ БА ОРОН НУТГИЙН БИЗНЕСИЙН ШИНЭ БОЛОМЖ
Хол замын хөдөлгөөнд зорчихдоо байн байн зогсож биеэ сэргээж, жолооч ядарч зам тээврийн осол гаргахгүй байх нь чухал. Энэхүү зан үйлийг төлөвшүүлэх үүднээс Бүрэнтогтох, Хутаг-Өндөр суманд автомашины жолооч нар зогсох, амрах таатай орчин, нөхцөл бүхий Амралтын цэг байгуулахаар төлөвлөж байна. *Энд:*
» Аюулгүй зогсоол
» Цэвэр ариун цэврийн байгууламж
» Хоол, хүнсний үйлчилгээ
» Орон нутгийн иргэд үйлчилгээний бизнес эрхлэх, ажлын байртай болох боломж бүрдэнэ.

Түүнчлэн, энэхүү зам ашиглалтад орсноор жуулчид болон иргэдийн тав тухтай зорчих нөхцөл сайжирч, нутгийн аялал жуулчлалын салбар идэвхжинэ хэмээн үзэж байна. **ОМ**



Иргэд ярьж байна

“Зам дагаж хөгжил ирнэ гэдэгт итгэж байна”

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Их-Уул багийн иргэн Д.Оюун-Эрдэнэтэй ярилцлаа. Д.Оюун-Эрдэнийн гэр бүл Хөх Хөтөлийн алманд хоолны газар нээж, үйлчилгээ үзүүлж иржээ.



Танай гэр бүл энэ бизнесээ хэзээнээс эхлүүлсэн бэ?
Анх аав, ээж хоёр маань зах зээлийн нийгэмд шилжих үеэр 1992 онд хоолны газар нээн, Хөх Хөтөлийн даваагаар зорчин яваа хүмүүст халуун хоол, цайгаар үйлчилж эхэлсэн. Бидний хувьд өв залгамжилсан бизнес болгон үргэлжлүүлж байна. Би өөрөө эндээ 10 гаруй жил биечлэн ажиллаж байна. **Хөх Хөтөлийн давааны замын хүндрэл, бэрхшээл таны бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлдөг вэ?**
Бидний хувьд мал аж ахуйгаа өсгөхийн зэрэгцээ өөр зүйл хийж давхар орлоготой болох боломжтой. Гэхдээ дэд бүтэц муу тул хоол хүнс, зочид буудал, үйлчилгээний бизнес эрхлэхэд хүндрэлтэй байна. Манай бизнест хамгийн том нөлөөлөгч хүчин зүйл бол зам. Одоогоор хатуу хучилтгүй, шороон замтай тул байгалийн хүчин зүйлд амархан өртөж, үер ус, салхи шуурганы нөлөөгөөр зам эвдэрч, тоосжилт их гардаг. Үүний улмаас зөвхөн иргэдийн зорчих хөдөлгөөн төдийгүй үйлчилгээний чанар, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, мал сүргийн эрүүл мэндэд ч сөргөөр нөлөөлдөг. Шороон замын тоосжилт хавар, намрын улиралд маш их болдог. Тоосноос болоод малын уушги муудах, байнга ханиалгах, нүд, чихний үрэвсэл үүсэх зэрэг сөрөг үр дагавартай. Ийм нөхцөлд хоол үйлчилгээ явуулахад мэдээж хүндрэлтэй. Бид цонхондоо тоосны тор татаж, замын тоос дарах зориулалт бүхий усны насос хүртэл худалдаж авсан.

Байршлын хувьд энэ газар Хөвсгөл аймгийн баруун зах гэж тооцогддог. Бараа, бүтээгдэхүүн, хүнсний ногоо зэргээ татаж авахад цаг хугацааны хувьд асуудал үүсдэг үү?
Манай бүс нутгаар Хөвсгөл аймгийн баруун сумдын (Цагаан-Уул, Цэцэрлэг) оршин суугчид, ажилтан, албан хаагчид байнга зорчдог. Гэвч замын чанар муу тул өвөл цасан шуурганд гацах, дугуй хагарах, техник гэмтэх, удаан явах зэргээр олон саад тулгардаг. Ийм нөхцөлд бидний зүгээс зам дагуу амрах, хооллох, зогсоолын үйлчилгээ үзүүлэх зайлшгүй шаардлагатай. Аялагчдын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа ч замын нөхцөл тааруу тул манай нутгийг тойрон зорчдог. Хэрэв замыг шинэчлэх юм бол манай бүс нутгаар зорчих жуулчдын урсгал нэмэгдэж, орон нутгийн эдийн засаг, үйлчилгээний салбар идэвхжинэ гэж боддог. **Хатуу хучилттай зам тавьснаар ямар давуу тал, боломжууд үүсэх бол?**
Хэрэв хатуу хучилттай зам баригдвал хамгийн түрүүнд орчин үеийн ариун цэврийн байгууламж бүхий зоогийн газар, амралтын үйлчилгээ бүхий цогц төв байгуулах мөрөөдөлтэй. Энэ нь зөвхөн манай бизнес төдийгүй зам дагуу байдаг айл өрхүүдийн амьдрах нөхцөл, иргэдийн ая тухтай зорчих хөдөлгөөн, аялал жуулчлал нэмэгдэх, орон нутгийн агаарын чанарт хүртэл эерэг нөлөө үзүүлнэ. “Хургатай Хайрхан” ХХК-ийг энд зам тавих гэж байгаа гэж сонссон. Замаа яаралтай бариасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байна. Хөвсгөл аймгийн төвөөс Цэцэрлэг, Согоот хүртэлх нутгийн бүх иргэдийн амьдрах, ажиллах нөхцөл энэ замаар дамжин сайжрах боломжтой. Одоо хамгийн их хэрэгтэй байгаа зүйл бол зам л байна. **ОМ**

Байгаль орчин

БАЙГАЛЬ ЭХЭЭ ХҮНДЭЛЖ, ИРЭЭДҮЙГЭЭ ХАМГААЛНА

“Хургатай Хайрхан” ХХК 2024 онд байгаль орчныг хамгаалан дэмжих чиглэлээр хэд хэдэн онцлох ажлыг санаачлан хэрэгжүүлжээ. Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт, үндэсний хөдөлгөөнд идэвхтэй оролцох, соёлын өвийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр өргөн хүрээг хамарсан эдгээр ажлаас тоймлон хүргэж байна.

БУЛНАЙ НУРУУНЫ ОЙ 10,000 ШИНЭС МОДООР ТЭЛЖЭЭ

“Хургатай Хайрхан” ХХК Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оноос эхлэн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний аяныг дэмжиж, 2030 он гэхэд 10 сая мод тарих үүрэг хүлээсэн.

Энэ хүрээнд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд мод үржүүлгийн газар байгуулж, суулгац бэлтгэх, шилжүүлэн суулгах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Тус компани анхны мод тарих ажлаа 2012 онд хийж, Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газартай хамтран Булнай нурууны байгалийн цогцолборт газрын дөрвөн өөр байршилд нийт 75 мянган шинэсний суулгац тарьжээ.

Энэ нь эвдэрсэн ойн бүс нутгийг арилгах, бүс нутгийн биологийн олон янз байдал, ойжуулалтын хүчин чармайлтыг дэмжсэн хэрэг байв. Тарьсан суулгацыг байгалийн жамаар ургуулж үлдээсэн бөгөөд 2024 онд хийсэн судалгаагаар 10,000 мод байгалийн нөхцөлд 4 метр гаруй өндөрт бүрэн ургасан гэсэн тооцоо гарчээ. Энэ нь мод тарихдаа тоо, чанарыг чухалчилдаг, амьдрах чадвар, амьдрах орчиндоо анхаарч байдгийн бодит жишээ юм.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙГ ИРГЭДЭД НЭЭЛТТЭЙ ТАЙЛАГНАЖ БАЙНА

“Хургатай Хайрхан” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас жил бүр баталдаг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлж, үүний хүрээнд 2024 онд хоёр удаа байгаль орчны аудитыг амжилттай хийжээ.

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ онцгой байдлын бэлэн байдал, хог хаягдлын менежментийн тогтолцоог сайжруулсан.

Үүний үр дүнд хайгуулын баазыг гал унтраах шинэчилсэн тоног төхөөрөмжөөр хангаж, хог хаягдлын менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, хог хаягдлыг дахин боловсруулах зорилгоор ангилан ялгах, тусгай зөвшөөрөлтэй газар тээвэрлэх, булшлах зэрэг ажлыг үр дүнтэй зохион байгуулж, бүрэн хэрэгжүүлж байна.

Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хянах үүднээс байгаль орчны мониторингийн байгууллага, итгэмжлэгдсэн лабораториудтай хамтран ажиллаж, шаардлагатай дээжүүдийг тогтмол илгээн шинжлүүлж байна.

Мөн усны зохистой хэрэглээг хэвшүүлэх зорилгоор худагт тоолуур суурилуулах бөгөөд ийнхүү бүртгэснээр ашиглах усны төлбөрийг орон нутагт хуулийн дагуу төлөх боломж бүрдэх юм. Улмаар усны нөөцийг хамгаалахад чухал нөлөө үзүүлнэ. Эдгээр ажлын явц болон үр дүнг орон нутгийн иргэдэд нээлттэй тайлагнаж, мэдээлэл солилцон ажиллах юм.



Булнайн нурууны байгалийн цогцолборт газар.

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ

“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн талбайд археологи, палеонтологийн дурсгалт зүйлс илэрсэн тохиолдолд соёлын өвийг хэрхэн хамгаалах талаар Соёлын өвийг хамгаалах тухай хууль, холбогдох журам, мөн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дагуу компаниас өөрийн ажилтнуудад зориулан “боломжит олдворыг” хэрхэн таних, мэдээлэх, хамгаалах, сэргээх талаарх сургалтыг зохион байгуулжээ. **ОМ**



Тогтвортой хөгжлийн төлөө

2024 ОНЫ ОНЦЛОХ 15 АЖИЛ

2024 онд “Хургатай Хайрхан” ХХК-иас нийгмийн хариуцлагын хүрээнд Хөвсгөл аймаг болон орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр олон талт ажлуудыг амжилттай хэрэгжүүллээ. Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт, байгаль хамгаалал зэрэг олон чиглэлд хүрч ажилласнаас дараах 15 ажлыг онцлон нэрлэж байна. Эдгээр ажил нь тоон үзүүлэлтээс гадна хүний хөгжил, орон нутгийн амьдралд өгч буй үр нөлөөгөөрөө онцлог байлаа. “Хургатай Хайрхан” ХХК нь орон нутагтай хамтран хөгжүүлэх урт хугацааны үзэл баримтлалд тулгуурлан хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна.

Спортод чиглэсэн олон талт дэмжлэг

Нийтийн биеийн тамирыг дэмжих хөрөнгө оруулалт 2024 оны онцлох амжилтын нэг байлаа. Хөвсгөл аймгийн Биеийн тамир, спортын газартай байгуулсан гэрээний дагуу “Хургатай Хайрхан” ХХК ивээн тэтгэж, нийт 3000 гаруй тамирчдыг спортын 6 төрлийн тэмцээн, уралдаанд оролцох боломжийг олгосон. Энэ нь зөвхөн тэмцээн уралдаан зохион байгуулах асуудал биш, тэмцээний шагнал, техник хэрэгсэл, бэлтгэл сургуулилтын орчин нөхцөлөөр хангах зэрэг алс хэтийн хөгжлийн үндэс суурь болж байгааг орон нутгийн спортын холбоод онцолж байна.

1. Бадминтоны өсвөрийн болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн: Мөрөн хотноо зохиогдсон Бадминтоны өсвөрийн болон насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 539 тамирчин оролцжээ. 2024 оны дөрөвдүгээр сарын 19-21-ний өдрүүдэд



Нийт 3000 орчим тамирчин оролцсон, 6 төрлийн спортын тэмцээн, уралдааныг ивээн тэтгэж, хамтран ажилласан байна.



зохиогдсон тэмцээнд өсвөрийн ангилалд 20 сургуулийн 423 тамирчин өрсөлдсөн бол насанд хүрэгчдийн ангилалд 116 тамирчин оролцож, авхаалж самбаагаа сорьжээ.

2. Аймгийн залуучуудын жүдо бөхийн тэмцээн: Эрэгтэй, эмэгтэй 52 жинд 24 байгууллагын 426 орчим тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорьж барилдсан Хөвсгөл аймгийн залуучуудын жүдо бөхийн тэмцээнийг дэмжин ажиллав. Уг тэмцээн 2024 оны хоёрдугаар сард Мөрөн хотноо зохиогдсон.

3. Залуучуудын аймаг болон улсын аварга шалгаруулах таеквондогийн

тэмцээн: 2024 оны гуравдугаар сарын 31-нээс дөрөвдүгээр сарын 3-ны өдрүүдэд зохиогдсон Залуучуудын аймаг болон улсын аварга шалгаруулах таеквондогийн тэмцээний үйл ажиллагааны бүх зардлыг гаргаж, хамтран зохион байгуулав. Мөн “Хургатай Хайрхан” ХХК-ийн зүгээс “Хүчит Шонхор” клубт 100 ширхэг дэвжээ, иж бүрэн хамгаалалт, хэрэгсэл гардуулан өгөв.

4. Өсвөрийн рагбигийн аварга шалгаруулах тэмцээн: “Хургатай Хайрхан” ХХК нь Монголын Рагбигийн Холбоотой хамтран 2024 оны дөрөвдүгээр сарын 27-28-нд “Хургатай

Хайрхан Цом-2024” Өсвөрийн Рагби аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулсан ба уг тэмцээнд 4 насны ангилалд нийт 12 сургуулийн 756 сурагчид оролцлоо.

5. “Ирээдүйн хүчтэн” дэвжээний цомын тэмцээн: Хоймор нутгийн “Ирээдүйн хүчтэн” дэвжээнээс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг өсвөр үе, залуучуудын цомын аварга шалгаруулах үндэсний бөхийн барилдааны ерөнхий ивээн тэтгэгчээр “Хургатай Хайрхан” ХХК ажиллаж, орон нутгийн уламжлалт спортын хөгжлийг дэмжихэд хувь нэмрээ оруулжээ. Уг тэмцээн нь 2024 оны зургаадугаар сарын

9-ний өдөр 2001-2003, 2004-2006, 2007-2008, 2009-2010 гэсэн 4 насны ангиллаар зохиогдсон бөгөөд Хөвсгөл аймгийн 18 сургууль, дэвжээний бөхчүүд төдийгүй Орхон аймгийн 110 бөх уран мэхийг уралдуулан барилдсан юм.

6. Үндэсний шагайн харваан аварга шалгаруулах тэмцээн: Монгол Улсад биеийн тамир, спортын холбоо үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд Хөвсгөл аймгийн Үндэсний шагайн харваан аварга шалгаруулах тэмцээний ерөнхий ивээн тэтгэгчээр “Хургатай Хайрхан” ХХК ажиллав. Тус тэмцээнд 24 багийн 200 гаруй харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдөв.

Боловсролд оруулсан бодит хөрөнгө оруулалт

Хүүхэд, залуусын боловсрол, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих нь “Хургатай хайрхан” компанийн тогтвортой хөгжлийн стратегийн нэг чухал хэсэг юм.

7. Сургалтын тэтгэлэг: Өнөөдрийн их, дээд сургуулийн оюутнууд бол маргаашийн манлайлагчид бөгөөд тэдний мэдлэг, алсын хараа нь Монгол Улсын ирээдүйг тодорхойлно. Ийм итгэл үнэмшил дээр тулгуурлан, компани 2012 оноос хойш орон нутгийн залуусыг дэмжиж, тэдний бүтэн боломжийг нээн илрүүлэх замаар урт хугацааны тогтвортой орон нутгийн хөгжил, чадавхыг бэхжүүлэх зорилготой тэтгэлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн.

Тус хөтөлбөрийн хүрээнд жил бүр 15 хүртэлх оюутанд тэтгэлэг олгодог. 2024

Богино хугацааны мэргэжил, хөгжлийн сургалт: Ажилтай ирээдүй

“Овоот” коксжих нүүрсний цогц төслийн ирээдүйн ажиллах хүчнийг орон нутгаас бүрдүүлэх, иргэдийн гадаад хэл, компьютерын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх үүднээс богино хугацааны мэргэжил, хөгжлийн хэд хэдэн сургалтыг зохион байгуулжээ. Эдгээр богино хугацааны сургалтууд нь хувь хүнийг хөгжүүлээд зогсохгүй ажил эрхлэх гарцыг бий болгох зорилготой.

10. Мэргэжлийн тогоочийн сургалт: Цэцэрлэг сумын 5 иргэнийг “Мэргэжлийн тогоочийн танхимын сургалт”-д хамруулав. /2024.10.07-25/ Мэргэжлийн тогоочоор бэлтгэгдсэн эдгээр иргэд цаашид “Овоот” коксжих нүүрсний цогц

“Ногоон тэжээл” хөтөлбөр: 600 өрхийг хямд тэжээлээр хангав

12. “Овоот” коксжих нүүрсний цогц төслийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас малын өвс, тэжээл бэлтгэх “Ногоон тэжээл” хөтөлбөрийг дөрөв дэх жилдээ хэрэгжүүлээд байна. Тус хөтөлбөрийг тогтвортой хөгжлийг дэмжин ажиллах чиглэлээр Цэцэрлэг сумын иргэдтэй

Хандив, тусламжийг үр дүнтэй чиглүүлэв

13. Дизель генератор: Цэцэрлэг сумын аж ахуйн нэгж байгууллагуудыг “Тэсийн илч” ХХК дулаанаар хангадаг. Тус компанид “Хургатай Хайрхан” ХХК-ийн зүгээс 130 кВт дизель түлшээр ажилладаг генераторыг хандивлаж, өвлийн улирлын эрсдэлээс сэргийлжээ. Учир нь Цагаан-Уул сумаас Могойн голын чиглэлийн 35 кВ агаарын шугамд байнга гэмтэл гардгийн улмаас удаан хугацаагаар эрчим хүч тасалдах асуудал үүсдэг байна. Үүний улмаас халаалтын шугам хоолой хөлдөх эрсдэл бий болдог аж.

онд Хөвсгөл аймгаас нийт 16 оюутанд бүтэн жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгогдсон байна.

8. Олимпиад: Улсын физикийн 35 дугаар олимпиадыг Хөвсгөл аймагт зохион байгуулахад ивээн тэтгэсэн. Мөрөн хотноо болсон энэхүү олимпиадад 21 аймаг, нийслэлийн 22 багийн 144 багш, сурагч оролцсон юм.

9. Байгаль орчны хөтөлбөр: Зориг сангаас 2011 оноос эхлэн “Байгаль орчны тэтгэлэгт хөтөлбөр” (EFP)-ийг хэрэгжүүлж байна. “Хургатай хайрхан” ХХК 2024 онд дөрөв дэх жилдээ дэмжин ажиллажээ. Энэ хугацаанд байгаль орчны асуудалд анхаарал хандуулдаг, хувь нэмрээ оруулах, өөрийгөө хөгжүүлэх хүсэлтэй 100 залуу мэргэжилтэн уг хөтөлбөрт хамрагдаад байгаа юм.

төсөлд ажиллах боломжтой бөгөөд төслийн үйл ажиллагаа эхэлснээр ажилтнуудын хоол хүнс бэлтгэх, үйлчилгээ зэрэгт 50 гаруй ажлын байр бий болох юм.

11. Англи хэл, компьютерын сургалт: Улаанбаатар хотын мэргэжлийн багш нартай хамтран 4 сарын хугацаанд англи хэл, компьютерын цогц сургалт зохион байгуулсан. Нийт 60 цагийн танхим, 96 цагийн онлайн сургалтад “Хургатай Хайрхан” ХХК-ийн орон нутаг дахь ажилтнууд, тэдний гэр бүлийнхэн болон нутгийн иргэд хамрагдсан байна. Энэ төрлийн сургалтуудыг 2025 онд илүү өргөн хүрээнд үргэлжлүүлэн зохион байгуулахаар төлөвлөжээ.

хамтран хэрэгжүүлдэг байна. “Ногоон тэжээл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад 600 өрхийг хөнгөлөлттэй тэжээлээр хангаж, 95 иргэнийг улирлын чанартай ажлын байраар хангажээ. 2024 онд нийт 16 мянга гаруй боодол өвс, тэжээл бэлтгэсэн.

14. Гал тогооны тоног төхөөрөмж: Дотуур байрандаа 20-25 хүүхэдтэй, 70-80 хүүхэд суралцдаг Могойн бага сургуулийн 50 жилийн ой 2024 онд болж өнгөрлөө. Энэ үеэр сурагчдын хоол хүнсний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хөргөгч, шарах шүүгээг хандивлалаа. Цаашид “Хургатай Хайрхан” ХХК орон нутгийн хүүхдүүдийн хичээл сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахаар зорьж буй юм.



“Хургатай Хайрхан” ХХК-ийн Захирал Сэмуэл Боулес “Байгаль орчны манлайлал хөтөлбөр”-ийн оролцогчидтой уулзлаа.

Цэцэрлэг сумын 5 иргэн мэргэжлийн тогоочийн сургалтад хамрагдав.



Мэдээллийн ажилтнуудын өдөрлөг болов

2024.08.10

15. “Хургатай Хайрхан” ХХК-ийн удирдлагын баг Цэцэрлэг суман дахь мэдээллийн ажилтнууддаа компанийн үйл ажиллагаа, цаашдын төлөвлөгөөг танилцуулах өдөрлөгийг Овоотын хайгуулын баазад зохион байгуулав.

Өдөрлөгийн үеэр “Овоот” коксжих нүүрсний цогц төслийн хэрэгжилт, бүс нутагт үзүүлэх үр өгөөжийн талаар мэдээлэл өгч, мэдээллийн ажилтнууд төслийн талаарх орон нутгийг иргэдийн хүлээлт, санал бодлыг танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэв. **ОМ**

Австралийн туршлага:

2024 оны гуравдугаар сард Хөвсгөл аймгийн иргэдийн төлөөллийг оролцуулсан туршлага судлах аяллыг Австрали Улсад зохион байгуулсан билээ. Энэхүү аяллыг Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци санаачлан, “Хургатай Хайрхан” ХХК-ийн ивээн тэтгэлгээр хэрэгжүүлсэн юм. Аяллын зорилго нь уул уурхай нь байгаль орчин, аялал жуулчлал, хөдөө аж ахуй зэрэг салбаруудтай хэрхэн зөв зохистой уялдаж, бүс нутгийн хөгжилд эерэгээр нөлөөлж буй туршилагатай танилцах байв. Танилцах аялалд Зам, тээврийн хөгжлийн яам, Байгаль орчны яам (Тухайн үеийн нэрээр), Хөвсгөл аймгийн болон Цэцэрлэг сумын ИТХ-ын зарим төлөөлөгчид, “Хургатай Хайрхан” ХХК-ийн удирдлага, олон нийттэй харилцах ажилтнууд оролцсон байна.



Ньюкасл хотын захирагч Хатагтай Нуатали Нелмес (Ms Nuatali Nelmes)-тэй уулзав.

Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, уул уурхай зэрэгцэн хөгжсөн Хантерийн хөндий

Австрали орчин үеийн туршлагыг хэрэгжүүлсэн зуу гаруй жилийн туршилагатай уул уурхайн бүтээн байгуулалтаараа дэлхийд тэргүүлдэг билээ. Хятад, АНУ, Энэтхэгийн дараа дөрөвдүгээрт ордог дэлхийн хамгийн том нүүрс үйлдвэрлэгчдийн нэг юм.

Судалгааны багийнхан эхлээд Ньюкасл хотод зочилж, хотын дарга хатагтай Нуатали Нелместэй уулзав. Тэрээр Хантерийн хөндийн нүүрсний уурхайн салбар Ньюкасл хотын хөгжилд хэрхэн үр өгөөжөө өгсөн талаар танилцууллаа. Ньюкасл боомт нь Австралийн нүүрсний экспортын гол төвүүдийн нэг бөгөөд жилд 140-150 сая тонн нүүрс тээвэрлэдэг бөгөөд нүүрсний уурхайн салбар болон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд хоорондоо нягт уялдаатай байдаг байна.

Багийн судалсан дараагийн чухал газар бол үзэсгэлэнт байгалиараа Австрали даяар алдартай Хантерийн хөндий байв. Мөн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, уул уурхай олон арван жилийн турш хамтдаа хөгжсөн газар юм. Онгон байгаль, тансаг хоол, дэлхийн жишигт нийцсэн усан үзмийн тариалангаар зугаацахын тулд гадаад, дотоодын жуулчид Хантерийн хөндийд зочилдог

байна. Мөн цэвэр цусны хурдан морьдыг өсгөн үржүүлэх, сургах чиглэлээр дэлхийд алдартай газар юм. Энд Австралийн хамгийн том нүүрсний уурхайн төвлөрөл байдаг бөгөөд жилд 1.5 саяас 25 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай 20 гаруй нүүрсний уурхай ажилладаг билээ.

Судалгааны багийнхан эдгээр уурхайн нэг болох “Рикс Крик” нүүрсний уурхайд зочилж, нөхөн сэргээлт, байгаль орчны хяналт шинжилгээний ажлын туршилагатай танилцлаа. Хантерийн хөндийд үйл ажиллагаа явуулж буй бүх нүүрсний уурхайн нэгэн адил тоос шороо, дуу чимээг бууруулахад ихээхэн анхаарал хандуулж, хэрхэн ажиллаж байгааг нутгийн иргэд, орон нутгийн удирдлагын

оролцоотойгоор нээлттэй хянаж байдаг байна. Уурхайн лицензийн талбайн нутаг дэвсгэрт нөхөн сэргээлт хийсэн газар нутгийг малаа бэлчээдэг хөрш зэргэлдээх тариаланчдад олгох боломжийг олгодог юм.

Мөн аяллын багийнхан Хантерийн хөндийд үйл ажиллагаа явуулдаг, дотоодын болон олон улсын зах зээлд, дэлхийн жишигт нийцсэн дарсны үйлдвэрүүдийн нэг болох Hollydene Estate Winery-д зочиллоо. Энэхүү дарсны үйлдвэр нь хэд хэдэн нүүрсний уурхайн ойролцоо байрладаг боловч дарсны чанар, нутгийн байгалийн үзэсгэлэнт байдал, дарсны амталгаа, өндөр чанартай ресторан зэргээрээ алдартай билээ. Олон жуулчид түүний дарсыг амтлахаар ирдэг. Энэ бүс нутагт олон

тооны дарсны үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дарсны үйлдвэрлэл, аялал жуулчлалыг амжилттай хослуулж, олон ажлын байр бий болгодог байна. Энэ бол хөдөө аж ахуй, аялал жуулчлал, уул уурхай бие биенээ дэмжиж, зэрэгцэн оршиж байгаагийн амжилттай жишээ юм.

Хантерийн хөндийд очсоны дараах аяллаа Австралийн нүүрс олборлолт нь байгаль, аялал жуулчлал, хөдөө аж ахуйтай зэрэгцэн оршдог өөр нэг бүс нутаг болох Сиднейгээс өмнө зүгт орших Иллаваррагийн сав газар руу үргэлжлүүлэв. “Линфокс” ложистикийн компани “Хургатай Хайрхан” ХХК-д ашиглахаар төлөвлөж байгаа шиг орчин үеийн хүнд даацын автомашинаар нүүрс тээвэрлэж, үр бүтээлтэй

тээвэрлэж байгааг энд гэрчлэв. Энэхүү нүүрс тээвэрлэлт нь нийтийн эзэмшлийн зам талбай, түүний дотор замын хөдөлгөөн ихтэй хүн ам суурьшсан газруудаар дамжиж явдаг.

Уул уурхай бол Хантерийн хөндий ба Иллаварра мужид чухал салбар юм. Энэ нь хөдөө аж ахуй, аялал жуулчлалтай нягт уялдаатай, байгаль орчинд ээлтэй байдлаар нямбай хөгжиж байгаа учраас ихээхэн ач холбогдолтой юм. Бүс нутгийн эдийн засаг, иргэдийн амьдралын чанарт эерэг нөлөө үзүүлдэг билээ. Судалгааны багийнхан байгалийн баялгийг хэрхэн хариуцлагатай ашиглаж, олон салбарыг дэмжин хөгжүүлж, эдийн засгийг тэлэх, ард иргэдийн амьдралд эерэг өөрчлөлт авчрах боломжтойг өөрийн нүдээр харж танилцлаа. **ОМ**



“Хургатай Хайрхан” ХХК-ийн Олон нийттэй харилцах мэргэжилтэн Т.Цогбадрах Австрали улсад хийсэн танилцах аялалд оролцсон сэтгэгдлээ хуваалцаж, “Овоот” коксжих нүүрсний цогц төслийг хөгжүүлэх шинэ гарц, чиглэлийг хэрхэн харж буйгаа онцоллоо.

Австрали улсад хийсэн туршлага судлах аяллын талаарх сэтгэгдлээсээ хуваалцана уу?

Миний хувьд Австралид хийсэн танилцах аялал үнэхээр дурсамжтай байсан. Байгалийн үзэсгэлэнт газруудаас эхлээд нутгийн хүмүүсийн халуун дулаан, найрсаг зан чанар хүртэл үнэхээр сэтгэл хөдөлгөсөн. Австрали инновацитай хослуулан ашигт малтмалын салбарынхаа тогтвортой хөгжилд хэр их анхаарч байгааг харах нь маш сонирхолтой байлаа.

Монголд хэрэгжүүлэхүйц онцгой санаа, туршлага юу байсан бэ?

Хантер Валлид өнгөрүүлсэн хугацаа энэ аяллын хамгийн оргил хэсэг нь байлаа. Уул уурхайн үйл ажиллагааг

бүс нутгийн хөгжилтэй хэрхэн уялдуулж, харилцан ашигтайгаар, бие биенээ дэмжин хөгжих боломжтойг харсан.

Байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтэд чиглэсэн бодлого, эдийн засгийн олон тулгуурт тогтолцоо нь үнэхээр суралцахуйц байлаа. Уул уурхай, хөдөө аж ахуй, усан үзмийн тариалан, аялал жуулчлал зэрэг салбарууд нэг дор зэрэгцэн хөгжихдөө орон нутгийнхаа иргэдийн амьжиргаанд шууд нөлөөлж, амьдралын чанарыг эрс сайжруулжээ. Тухайлбал, Хантерийн хөндийн бүс нутагт дэд бүтэц, төрийн үйлчилгээ нь сайн чанарын авто зам, чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ гэх байдлаар иргэддээ хүртээмжтэй хүрч байгаа нь нийгмийн хөгжил ямар өндөр түвшинд хүрснийг илтгэж байв. Энэ бүхэн уул уурхайн салбараас бүс нутгийнхаа эдийн засагт оруулж буй хувь нэмрийн үр дүн байсан.

Түүнчлэн орон нутгийн эдийн засаг нь уул уурхайгаас гадна хөдөө аж ахуй, аялал жуулчлалтай уялдсан олон төрлийн бизнесийг дэмждэг нь онцлог байлаа. Үүний үр дүнд орон

нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ нь зөвхөн дотооддоо биш, үндэсний болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай болсон байна.

Энэ аялал таны “Овоот” коксжих нүүрсний цогц төслийн талаарх үзэл бодолд хэрхэн нөлөөлсөн бэ?

Австралид хийсэн аялал маань “Овоот” коксжих нүүрсний цогц төсөл нь Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төдийгүй Монгол Улсын иргэдэд үр өгөөжөө өгөх боломжтой гэдэгт итгэх итгэлийг минь улам бататгалаа.

Хантерийн хөндийд хэрэгжүүлж буй хариуцлагатай, тогтвортой уул уурхайн загвар нь бидний төлөвлөгөөтэй маш төстэй юм. Манай компани уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаас гадна байгалийн тэнцвэрт байдлыг хадгалж, нутгийн иргэдийн амьжиргаанд урт хугацаанд бодитой, эерэг нөлөө үзүүлэх зорилготой. Хантерийн хөндийн туршлагаас санаа авч “Овоот” коксжих нүүрсний цогц төсөл Монгол Улсын тогтвортой хөгжлийн үлгэр жишээ төсөл болж, орон нутаг, ард иргэдийн хөгжлийг дэмжинэ гэдэгт улам итгэлтэй байна. **ОМ**



Хантерийн хөндийд нүүрсний 22 томоохон уул уурхай үйл ажиллагаа явуулдаг.



Уурхайгаас холгүйхэн орших дарсны аж ахуйд зочлов.